



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Өлзийт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/79/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn
Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: Гроут финанс аудит ХХК
Гүйцэтгэх захирал Б.Бямбадорж
Утас: 7772-1628
Цахим хаяг: Byambadorj@growthfinance.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 141
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Н.ТУНГАЛАГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Өлзийт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр 1,021,095.3 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 996,841.7 мянган төгрөг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 14 үндсэн зорилтын хүрээнд 91 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	218,196,729.35	106,347,526.18
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	156,051,617.88	44,928,624.56
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	156,051,617.88	44,928,624.56
3121	Төгрөг	156,051,617.88	44,928,624.56
31211	Төрийн сангийн харилцах	156,051,617.88	44,928,624.56
33	АВЛАГА	4,648,262.47	397,152.62
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,648,262.47	397,152.62
35	БАРАА МАТЕРИАЛ	57,496,849.00	61,021,749.00
351	Түүхий эд материал	605,000.00	-
354	Хангамжийн материал	56,891,849.00	61,021,749.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	132,926,624.79	150,145,749.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	132,926,624.79	150,145,749.35
392	Биет хөрөнгө	123,036,624.79	137,505,749.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	84,622,238.60	84,622,238.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	(17,377,598.59)	(20,193,474.19)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	36,413,297.00	46,543,464.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16,878,481.71)	(25,527,403.22)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	85,967,055.00	87,848,419.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(58,152,695.59)	(43,830,304.96)
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,799,709.00	9,799,709.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,599,708.92)	(2,999,708.88)
39217	Ном	1,242,810.00	1,242,810.00
393	Биет бус хөрөнгө	9,890,000.00	12,640,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	9,890,000.00	12,640,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	351,123,354.14	256,493,275.53
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	1,125,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,125,000.00
413	Өглөг	-	1,125,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,125,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	351,123,354.14	255,368,275.53
51	Засгийн газрын хувь оролцоо	351,123,354.14	255,368,275.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	200,662,400.00	200,662,400.00
51101	Өмч: - төрийн	200,662,400.00	200,662,400.00
512	Хуримтлагдсан үр дүн	141,451,939.66	45,696,861.05
51210	Өмнөх үеийн үр дүн	141,451,939.66	141,451,939.66
51220	Тайлант үеийн үр дүн	-	(95,755,078.61)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,009,014.48	9,009,014.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	351,123,354.14	256,493,275.53

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	857,292,104.00	939,711,965.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,279,504.00	51,765,465.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,279,504.00	51,765,465.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,279,504.00	51,765,465.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	35,000.00
120009	Бусад орлого	50,000.00	60,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	16,194,504.00	51,670,465.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	841,012,600.00	887,946,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	758,383,000.00	809,316,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	758,383,000.00	809,316,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	82,629,600.00	78,629,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	82,629,600.00	78,629,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	810,803,858.50	1,035,467,043.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	810,803,858.50	1,035,467,043.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	807,263,300.96	1,026,698,901.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	571,171,906.00	731,339,678.28
210101	Үндсэн цалин	374,686,052.82	441,430,940.31
210102	Нэмэгдэл	158,427,215.01	220,741,556.30
210104	Урамшуулал	38,058,638.17	69,167,181.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,725,147.72	90,494,277.39
210201	Тэтгэврийн даатгал	50,620,923.31	58,669,085.93
210202	Тэтгэмжийн даатгал	6,057,942.19	6,900,845.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,029,071.04	3,446,522.70
210204	Ажилгүйдлийн даатгал	2,970,803.42	3,446,522.70
210205	Эрүүл мэндийн даатгал	7,046,407.76	18,031,300.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,311,306.78	62,901,757.71
210301	Гэрэл, цахилгаан	4,508,615.86	4,679,812.11
210302	Түлш, халаалт	52,168,664.32	58,221,945.60
210303	Цэвэр, бохир ус	634,026.60	-
2104	Хангамж, бараа материалын зардал	-	13,205,700.00
210401	Бичиг хэрэг	-	7,530,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	5,675,000.00
2105	Нормативт зардал	60,770,325.00	60,338,825.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	632,800.00
210502	Хоол, хүнс	60,770,325.00	59,706,025.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	13,930,500.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	13,930,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,239,400.00	2,734,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,239,400.00	2,734,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,045,215.46	51,753,362.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,103,650.00	21,726,022.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,006,100.00	5,996,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,935,465.46	24,030,540.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,540,557.54	8,768,142.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	6,505,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,505,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,540,557.54	2,262,842.29
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,540,557.54	2,262,842.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	46,488,245.50	(95,755,078.61)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-

225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>46,488,245.50</u>	<u>(95,755,078.61)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	841,097,600.00	888,041,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	85,000.00	95,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	85,000.00	95,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,000.00	35,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	35,000.00
120009	Бусад орлого	50,000.00	60,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	841,012,600.00	887,946,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	758,383,000.00	809,316,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	758,383,000.00	809,316,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	82,629,600.00	78,629,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	82,629,600.00	78,629,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	822,876,584.75	999,164,493.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	822,876,584.75	999,164,493.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	819,336,027.21	990,396,351.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	571,171,906.00	731,339,678.28
210101	Үндсэн цалин	374,686,052.82	441,430,940.31
210102	Нэмэгдэл	158,427,215.01	220,741,556.30
210104	Урамшуулал	38,058,638.17	69,167,181.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,362,353.75	86,243,167.54
210201	Тэтгэврийн даатгал	50,620,923.31	58,669,085.93
210202	Тэтгэмжийн даатгал	6,057,942.19	6,900,845.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,029,071.04	3,446,522.70
210204	Ажилгүйдлийн даатгал	2,970,803.42	3,446,522.70
210205	Эрүүл мэндийн даатгал	11,683,613.79	13,780,190.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,089,042.46	62,901,757.71
210301	Гэрэл, цахилгаан	4,508,615.86	4,679,812.11
210302	Түлш, халаалт	63,946,400.00	58,221,945.60
210303	Цэвэр, бохир ус	634,026.60	-
2105	Нормативт зардал	60,770,325.00	59,777,125.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-
210502	Хоол, хүнс	60,770,325.00	59,777,125.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	13,500,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	13,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,139,400.00	3,504,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,139,400.00	3,504,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,803,000.00	33,129,822.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,752,200.00	27,132,822.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,050,800.00	5,997,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,540,557.54	8,768,142.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	6,505,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,505,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,540,557.54	2,262,842.29
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,540,557.54	2,262,842.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	18,221,015.25	(111,122,993.32)

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	18,221,015.25	(111,122,993.32)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	137,830,602.63	156,051,617.88
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	156,001,617.88	44,928,624.56

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	200,662,400.00	9,009,014.48	95,013,694.16	304,685,108.64
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	46,488,245.50	46,438,245.50
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	200,662,400.00	9,009,014.48	141,501,939.66	351,123,354.14
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	200,662,400.00	9,009,014.48	141,501,939.66	351,123,354.14
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(95,755,078.61)	(95,755,078.61)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	200,662,400.00	9,009,014.48	45,746,861.05	255,368,275.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Код	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2	1,024,494,800.00	996,841,651.03	27,653,148.97	97.30
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	21	1,024,494,800.00	996,841,651.03	27,653,148.97	97.30
Бараа, үйлчилгээний зардал	210	1,017,989,500.00	990,336,351.03	27,653,148.97	97.30
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2101	738,626,700.00	731,339,678.28	7,347,021.72	99.01
Үндсэн цалин	210101	453,801,500.00	441,430,940.31	12,370,559.69	97.27
Нэмэгдэл	210102	249,984,500.00	220,681,556.30	29,302,943.70	88.28
Урамшуулал	210104	34,840,700.00	69,167,181.67	(34,326,481.67)	198.52
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2102	91,433,600.00	86,243,167.54	5,190,432.46	94.32
Тэтгэврийн даатгал	210201	62,024,700.00	58,669,085.93	3,355,614.07	94.59
Тэтгэмжийн даатгал	210202	7,352,300.00	6,900,845.40	451,454.60	93.86
ҮОМШӨ ний даатгал	210203	3,676,000.00	3,446,522.70	229,477.30	93.76
Ажилгүйдлийн даатгал	210204	3,676,000.00	3,446,522.70	229,477.30	93.76
Эрүүл мэндийн даатгал	210205	14,704,600.00	13,780,190.81	924,409.19	93.71
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2103	65,129,600.00	62,901,757.71	2,227,842.29	96.58
Гэрэл цахилгаан	210301	6,703,200.00	4,679,812.11	2,023,387.89	69.81
Түлш, халаалт	210302	58,426,400.00	58,221,945.60	204,454.40	99.65
Нормативт зардал	2105	72,418,100.00	59,777,125.00	12,640,975.00	82.54
Хоол, хүнс	210502	72,418,100.00	59,777,125.00	12,640,975.00	82.54
Эд хогшил худалдан авах	2106	13,500,000.00	13,500,000.00	-	100.00
Урсгал засвар	210604	13,500,000.00	13,500,000.00	-	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2108	3,504,800.00	3,504,800.00	-	100.00
Мэдээллийн технологийн зардал	210806	3,504,800.00	3,504,800.00	-	100.00

Бараа үйлчилгээний бусад зардал	2201	33,376,700.00	33,069,822.50	246,877.50	99.26
Бараа үйлчилгээний бусад зардал	210901	27,379,700.00	27,132,822.50	246,877.50	99.10
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	210902	5,997,000.00	5,997,000.00	-	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		6,505,300.00	6,505,300.00	-	100.00
Бусад урсгал шилжүүлэг	2132	6,505,300.00	6,505,300.00	-	100.00
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	213209	6,505,300.00	6,505,300.00	-	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,024,494,800.00	885,718,657.71	138,776,142.29	86.45
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1310	819,823,000.00	809,316,900.00	10,506,100.00	98.72
Улсын төсвөөс санхүүжих	131001	819,823,000.00	809,316,900.00	10,506,100.00	98.72
Өмнөх оны үлдэгдлээс санхүүжих		126,042,200.00	-	126,042,200.00	-
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1320	78,629,600.00	76,366,757.71	2,262,842.29	97.12
Орон нутгийн төсвөөс	132001	78,629,600.00	76,366,757.71	2,262,842.29	97.12
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	120004	-	35,000.00	(35,000.00)	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1200041	-	35,000.00	(35,000.00)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4	156,051,617.88	156,051,617.88	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5	156,051,617.88	44,928,624.56	111,122,993.32	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	6	-	-	-	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	61	1	1	-	
АЖИЛЛАГСДЫН ТОО		27	27	-	
Удирдах ажилтан		1	1	-	
Гүйцэтгэх ажилтан		14	14	-	
Үйлчлэх ажилтан		12	12	-	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 47,634.8 мянган төгрөгийн 4 алдаа илэрсэн ба үүнээс 47,409.1 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан, 225.7 мянган төгрөгийн 1 алдааг залруулаагүй.

Залруулсан алдаа:

- Банкин дахь харилцах дансны үлдэгдлээс 18,171.0 мянган төгрөгийг касс дахь бэлэн мөнгөөр 2024 оноос буруу ангилан тайлагнаж ирсэн байна.

- Үндсэн хөрөнгийн тайлангийн эхний үлдэгдэл, орлого, зарлага, эцсийн үлдэгдлийг харгалзах ерөнхий дэвтрийн дансны дебет, кредиттэй тулган шалгахад зарлагын гүйлгээ эцсийн үлдэгдэл 26,488.1 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь акталсан хөрөнгийн бүртгэлийг үндсэн хөрөнгийн цэсээр хийгээгүйтэй холбоотой үүссэн байна.
- Санхүүгийн Acolous программ ашигладаг боловч хөрөнгөнд бүртгээгүй 2,000.0 мянган төгрөг, 2025 онд нярвын санхүүгийн программ худалдан авсныг зардалд бичсэн 750.0 мянган төгрөг, нийт 2,750.0 мянган төгрөгөөр хөрөнгийг нэмэгдүүлэх залруулга хийлээ.

Залруулагдаагүй алдаа:

- Нэр бүхий 1 ажилтны /06002 кодтой/ нийгмийн даатгалын шимтгэлийг 2025 оны 10-12 дугаар сард тайлагнаагүй ба тэтгэврийн даатгалд 201.9 мянган төгрөг, тэтгэмжийн даатгалд 23.7 мянган төгрөг, нийт 225.7 мянган төгрөгийг зардалд бүртгээгүй байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 үнэн зөв байх зарчмыг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 үнэн зөв байх зарчмыг хангаж ажиллах, цаашид алдааг давтан гаргахгүй байх.

Аудитаар залруулаагүй нийт 3,647.3 мянган төгрөгийн зөрчил илэрч, 3,582.4 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 64.9 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 4 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 3,647.3 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 11,396.9 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1. "Балансын урамшуулал олгох тухай" тус Архангай аймгийн Боловсролын газрын даргын 2025.09.03-ны өдрийн А/38 дугаар тушаал, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025.08.22-ны өдрийн Б/25 дугаар тушаалуудыг үндэслэн "2024 санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэсэн үндэслэлээр нягтлан бодогчид 1,559.0 мянган төгрөгийг олгосон нь хууль, журамд нийцэхгүй байна.

Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно": 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Төрийн албаны тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.Онцгой чухал буюу онцтүвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараахь хэлбэрээр шагнаж, урамшуулна: 51.1.4 "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3.1.2. Багш ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг олгохдоо зөвхөн "Хувь хүний орлогын албан татвар" 10 хувь 650.5 мянган төгрөг суутган 5,854.8 мянган төгрөгийг 26 ажилтанд олгохдоо суутган буюу ногдуулан төлөх 1,561.3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тайлагнаагүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дугаар зүйлийн 19.1 "Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин

хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна”: 19.1.1 "Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, 111, 112, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд тус тус заасан цалин хөлс, олговор" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

3.1.3 Нийгмийн даатгалын байгууллагад 2025 оны 2 дугаар сард нэр бүхий 2 ажилтны 1,925.3 мянган төгрөгийн цалин ба ногдох нийт шимтгэл 462.1 мянган төгрөгийг тайлагнаагүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дугаар зүйлийн 19.1 “Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна”: 19.1.1 "Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, 111, 112, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд тус тус заасан цалин хөлс, олговор" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

3.2 Зөвлөмж

Илрүүлэлт:

3.2.1 Бараа материалын тайлангийн эхний үлдэгдэл, орлого, зарлага, эцсийн үлдэгдлийг харгалзах ерөнхий дэвтрийн дансдын дебет, кредит, үлдэгдэлтэй тулган шалгахад орлогын гүйлгээ 2,429.6 мянган төгрөгөөр, зарлагын гүйлгээ 2,364.7 мянган төгрөгөөр, эцсийн үлдэгдэл 64.9 мянган төгрөгөөр тус тус зөрсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 “Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна: 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэснийг ханган ажиллаагүй.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах, алдааг давтан гаргахгүй байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс		Зөвлөмж
				Залруулсан	Залруулаагүй	

**Архангай аймгийн Өлзийт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл,
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн хөрөнгийн ангилал буруу	1	18,171.0			1	18,171.0	1	18,171.0				
Үндсэн хөрөнгийн алдаатай тайлагнал	1	26,488.1			1	26,488.1	1	26,488.1				
Программ хөрөнгөөр бүртгээгүй.	1	2,750.0	1	2,750.0			1	2,750.0				
Нийгмийн даатгалын шимтгэл тайлагнаагүй	1	225.7	1	225.7					1	225.7	1	225.7
Нийт дүн	4	47,634.8	2	2,975.7	2	44,659.1	3	47,409.1	1	225.7	1	225.7

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Балансын урамшуулал олгосон	1	1,559.0			1	1,559.0		
НДШ суутган буюу ногдуулаагүй.	1	1,561.3			1	1,561.3		
	1	462.1			1	462.1		
Бараа материалын алдаатай тайлагнал	1	64.9					1.0	64.9
Дүн	4	3,647.3	-	-	3	3,582.4	1	64.9

Нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
3 мэдээллийг хугацаа хоцроосон	1	-	1	-		
Дүн	1	-	1	-		